



# МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

2018 ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Урсгал ба хөрөнгийн данс 2018 онд 2,115 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 2,091 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 142 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн 118 сая ам.доллар байна.

Өнгөрсөн оны гүйцэтгэлтэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 1,038 сая ам.доллараар өсч, харин санхүүгийн дансны ашиг 502 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 3,486 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 5.8 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

## Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн онтой харьцуулахад 22%-иар өсч 12,438 сая ам.долларт хүрсэн ба худалдааны тэнцэл 676 сая ам.долларын ашигтай гарсан.

Тодруулбал, экспортын хувьд, чулуун нүүрсний экспорт 530 сая ам.доллараар (23%), зэсийн баяжмалын экспорт 399 сая ам.доллараар (25%) өсч, харин импортын хувьд СИФ нөхцөлөөр тооцсон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 694 сая ам.доллараар (41%), хэрэглээний бүтээгдэхүүний импорт 358 сая ам.доллараар (28%), нефтийн бүтээгдэхүүний импорт 323 сая ам.доллараар (41%) тус тус өссөн. Улмаар барааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 814 сая ам.доллараар буурчээ.

## Үйлчилгээний худалдаа

2018 онд үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 63%-иар буюу 766 сая ам.доллараар өсч 1,978 сая ам.долларт хүрсэн. Энэхүү алдагдлын өсөлтөд тээврийн үйлчилгээний дансны алдагдал 277 сая ам.доллараар, бусад үйлчилгээний алдагдал 211 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Мөн 2018 онд хийгдсэн түүвэр судалгаа, тооцоолуудын үр дүнгүүдээр статистик мэдээллүүдэд тусгасан нь нөлөөлсөн.

## Анхдагч орлого

Анхдагч орлогын данс 1,228 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 24%-иар буюу 385 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.


2018 онд гадаад бонд үнэт цаасны хүүгийн төлбөрт 294 сая ам.доллар, ногдол ашигт 210 сая ам.доллар, бусад зээлийн хүүгийн төлбөрт 558 сая ам.доллар болон арилжааны банкууд харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт нийт 159 сая ам.долларыг тус тус төлсөн байна.

## Хоёрдогч орлого


Хувийн гуйвуулга болон хандив тусламжийн шугамаар 2018 онд Монгол улс нийт 324 сая ам.долларыг буюу өнгөрсөн оноос 144 сая ам.доллараар илүү орлогыг хүлээн авчээ. Үүнд:

- Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан мөнгөн гуйвуулга өмнөх оны мөн үеэс 29%-иар, гадаад руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулга 54%-иар тус тус өсч, цэвэр дүнгээр 154 сая ам.долларын орлого авсан.
- Гадаад хандив тусламжийн орлого өмнөх оны мөн үеэс 124 сая ам.доллараар мөн өссөн байна.


Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл



Дүрслэл 2. Барааны худалдаа



Дүрслэл 3. Үйлчилгээний худалдаа



Хүснэгт 1. Хувийн гуйвуулга 2018 он (мян ам.доллар)

		Хүлээн авсан			Шилжүүлсэн		
		Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	KR	146,741	57%	▲ 34%	2,522	9%	▼ -65%
Америк	US	40,836	16%	▲ 38%	4,216	15%	▼ -63%
Хятад	CN	2,593	1%	▼ -47%	1,045	4%	▼ -90%
Гонг Конг	HK	3,045	1%	▲ 12%	311	1%	▼ -64%
Англи	GB	5,101	2%	▼ -57%	1,823	7%	▼ -40%
ОХУ	RU	5,275	2%	▲ 217%	2,866	11%	▼ -69%
Сингапур	SG	2,951	1%	▲ 17%	1,164	4%	▼ -45%
Швейцарь	CH	5,144	2%	▲ 5x	92	0%	▲ 100%
Герман	DE	6,341	2%	▲ 26%	489	2%	▼ -81%
Япон	JP	4,035	2%	▲ 18%	577	2%	▼ -77%
Бусад		37,325	14%	▲ 10%	12,132	45%	▼ -55%
<b>НИЙТ</b>		<b>259,386</b>	<b>100%</b>		<b>27,236</b>	<b>100%</b>	

## Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2018 онд Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын дүн 2,729 сая ам.доллар, хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал 555 сая ам.доллар буюу цэвэр дүнгээр 2,174 сая ам.долларын орох урсгалтай байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 642 сая ам.доллараар өссөн байна.

Шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг голлох улсаар нь авч үзвэл:

- Канад улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 881 сая ам.доллараар өсч 1,647 сая ам.доллар,
- Япон улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 152 сая ам.доллараар өсч 244 сая ам.долларт хүрсэн бол,
- Люксембург улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 183 сая ам.доллараар буурч 64 сая ам.доллар,
- Герман улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 106 сая ам.доллараар буурч 3 сая ам.долларын урсгалтай гарсан байна.

Харин эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 2018 онд уул уурхайн салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт өнгөрсөн оны гүйцэтгэлээс өссөн үзүүлэлттэй байна.

Салбаруудын хөрөнгө оруулалтын хэмжээг харьцуулбал:

- Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт 171 сая ам.доллараар,
- Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар 22 сая ам.доллараар өсч,
- Бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар 154 сая ам.доллараар,
- Тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар 39 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

## Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2018 онд 61 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 432 сая ам.доллараар буурсан байна.

Тайлант хугацааны голлох ажил гүйлгээг дурдвал:

- Хөгжлийн банк 500 сая ам.долларын бонд гаргасан,
- Димсам бондын үндсэн болон хүүгийн үлдэгдэл төлбөрт 147 сая ам.доллар,
- Чингис 500 бондын үндсэн болон хүүгийн үлдэгдэл төлбөрт 130 сая ам.доллар,
- Гэрэгэ, Мазаалай, Хуралдай, Чингис 1000 зэрэг бондуудын хүүгийн төлбөрт нийт 203 сая ам.доллар,
- ХХБ өөрийн гаргасан бондын хүүгийн төлбөрт 47 сая ам.долларыг эдийн засгийн харьяат буст тус тус төлжээ.

## Бусад хөрөнгө оруулалт

Энэ дансанд санхүүгийн дээрх дансуудад үл хамаарах бусад хөрөнгө оруулалтууд болох арилжааны, хөнгөлөлттэй, худалдааны зэрэг бүх төрлийн зээлүүд, бэлэн мөнгө ба харилцах хадгаламжийн дансны эх үүсвэрийг бүртгэдэг.

Тайлант онд манай улсад орсон бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэр 119 сая ам.долларын гарах урсгалтай байсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал 791 сая ам.доллараар муудсан үзүүлэлт юм. Энэхүү өөрчлөлтөд Засгийн газрын болон арилжааны банкуудын зээлийн ашиглалт буусан нь голлон нөлөөлсөн байна.


Хүснэгт 2. ГШХО, орох урсгал, улсаар (сая ам.доллар)

№	Үзүүлэлт	2018		2018/17	
		Дүн	Хувийн жин	Өөрчлөлт	
1	Австрали	16	1%	-27	▼
2	Америк	78	3%	-61	▼
3	Англи	19	1%	-6	▼
4	БНХАУ	358	13%	134	▲
5	Герман	3	0%	-106	▼
6	Голланд	4	0%	-64	▼
7	Хонг-Конг	79	3%	-23	▼
8	Канад	1,647	60%	881	▲
9	Люксембург	64	2%	-183	▼
10	ОХУ	18	1%	-12	▼
11	Сингапур	55	2%	-80	▼
12	Солонгос (өмнөд)	27	1%	17	▲
13	Турк	0	0%	-1	▼
14	Франц	15	1%	6	▲
15	Япон	244	9%	152	▲
16	Бусад	102	4%	16	▲
Нийт		2,729	100%	642	▲


Хүснэгт 3. ГШХО, орох урсгал, салбараар (сая ам.доллар)

№	Эдийн засгийн салбар	2018		2018/17	
		2017	2018	Өөрчлөлт	
1	Барилга	55	22	-34	▼
2	Боловсрол	1	1	0	▼
3	Боловсруулах үйлдвэрлэл	33	43	10	▲
4	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	297	143	-154	▼
5	Зочид буудал, байр, сууд болон нийтийн хоолны үйлчилгээ	23	10	-13	▼
6	Мэдээлэл, холбоо	5	8	3	▲
7	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	6	17	11	▲
8	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	54	224	171	▲
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	41	2	-39	▼
10	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	13	25	12	▲
11	Уул уурхай, олборлолт	1442	2130	688	▲
12	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	42	64	22	▲
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	21	21	0	▼
14	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	6	3	-2	▼
15	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	25	1	-24	▼
16	Бусад	22	15	-7	▼
Нийт		2086	2729	642	▲

Дүрслэл 4. Багцын хөрөнгө оруулалт (сая ам.доллар)



Дүрслэл 5. Бусад хөрөнгө оруулалт



## II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2018 онд цэвэр дүнгээр 33,637 сая ам.долларын үлдэгдэлтэй буюу өр төлбөртэй байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын дүн (актив) 6,149 сая ам.доллар байна. Үүний 58%-ийг гадаад валютын албан нөөц, 29%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 9%-ийг шууд хөрөнгө оруулалт, 5%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Харин Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 39,786 сая ам.долларт хүрчээ. Үүний 51%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 37%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 12%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 5%-иар буюу 1,606 сая ам.доллараар өссөн байна. Үүнийг

- Ерөнхий бүтцээр авч үзвэл, гадаад актив 11%-иар буюу 595 сая ам.доллараар, гадаад пассив 6%-иар буюу 2,202 сая ам.доллараар тус тус өссөн,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц 2,165 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын позиц 45 сая ам.доллараар, албан нөөц 533 сая ам.доллараар тус тус өсч, багцын хөрөнгө оруулалтын позиц 71 сая ам.доллараар буурснаар тайлбарлагдаж байна.
- Тайлант улирлын позицийн өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, төлбөрийн тэнцлийн урсгалаар -2,233 сая, ханшийн өөрчлөлтөөр 119 сая, бусад өөрчлөлтөөр 277 сая, үнийн өөрчлөлтөөр 230 сая ам.доллараар тус тус өөрчлөгджээ.

### Шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 54%-ийг буюу 10,995 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 46% буюу 9,228 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь харуулбал:

- Канад улсаас 5,990 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 30%,
- БНХАУ-аас 4,917 сая ам.доллар буюу 24%,
- Сингапур улсаас 1,635 сая ам.доллар буюу 8%,
- Люксембург улсаас 1,672 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 8%-тай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтыг манай улсад тус тус оруулсан байна.

### Багцын хөрөнгө оруулалт

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад активын үлдэгдэл 2018 оны жилийн эцэст 290 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 8%-иар өссөн бол гадаад пассивын үлдэгдэл 4,887 сая ам.долларт хүрч 1%-иар буурсан үзүүлэлттэй байна.


**Актив:** Эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл Хонг-Конг 38%, АНУ 16%, Сингапур 10%, Австрали 8%, Их Британ 6%-ийг тус тус эзэлж байна.

**Пассив:** Эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал АНУ 16%, Их Британ 8%, Люксембург 5%, Сингапур 3%, Хонг Конг 3%, үлдсэн 54% нь хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа учраас хөрөнгө оруулагчийн харьяалах улсыг тодорхойлох боломжгүй байна.


Хүснэгт 4. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2017	12/31/2018	Өөрчлөлт	
			дүн	хувь
<b>Гадаад хөрөнгө оруулалтын позиц</b>	<b>-32,031</b>	<b>-33,637</b>	<b>1,606</b>	<b>5%</b>
<b>I. Гадаад актив</b>	<b>5,553</b>	<b>6,149</b>	<b>595</b>	<b>11%</b>
1. Шууд хөрөнгө оруулалт	495	533	38	8%
2. Багцын хөрөнгө оруулалт	268	290	21	8%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	00	00	00	90%
4. Бусад хөрөнгө оруулалт	1,782	1,784	02	0%
5. Нөөц актив	3,008	3,542	533	18%
<b>II. Гадаад пассив</b>	<b>37,584</b>	<b>39,786</b>	<b>2,202</b>	<b>6%</b>
1. Шууд хөрөнгө оруулалт	18,020	20,223	2,203	12%
2. Багцын хөрөнгө оруулалт	4,937	4,887	-50	-1%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	00	01	01	85%
4. Бусад хөрөнгө оруулалт	14,628	14,675	48	0%


Дүрслэл 6. Гадаад актив, пассив



Дүрслэл 7. Шууд ХО-ын үлдэгдэл, 2018 он



Дүрслэл 8. Багцын ХО-ын үлдэгдэл, 2018 он



### III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 28,715 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 1,222 сая ам.доллараар өссөн байна.

**Улсын салбар:** Засгийн газрын гадаад өр 137 сая ам.доллараар буурч 7,184 сая ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 5 сая ам.доллараар өсч 2,030 сая ам.долларт хүрчээ.

**Бусад салбар:** Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд энэ дүн өнгөрсөн оны мөн үеэс 1,354 сая ам.доллараар өсч 19,500 сая ам.долларт хүрээд байна.

#### Банкны салбар

Банкны салбарын гадаад өр төлбөрийн үлдэгдэл 2018 оны жилийн эцэст 2,230 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 35 сая ам.доллараар өсчээ.

Гадаад өрийн 38%-ийг урт хугацаат зээл, 28%-ийг бонд өрийн бичиг, 20%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 15%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат арилжааны зээлийн үлдэгдэл харгалзан 842 сая ам.доллар, 437 сая ам.долларт хүрсэн үзүүлэлттэй байна.

#### Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өр төлбөр 2018 оны жилийн эцэст 17,270 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 1,318 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Салбарын нийт зээлийн 53% буюу 9,228 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.


Эдийн засгийн харьяат аж ахуйн нэгжүүдийн гадаадаас хүлээн авсан экспортын барааны урьдчилгаа болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын барааны төлбөрийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 288 сая ам.доллар болсон байна.

Хүснэгт 5. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)


Үзүүлэлт	12/31/2017	12/31/2018	өөрчлөлт		* %
			дүн	хувь	
<b>Нийт гадаад өр</b>	<b>27,493</b>	<b>28,715</b>	<b>1,222</b>	<b>4%</b>	<b>100%</b>
<b>I. Засгийн газар</b>	<b>7,321</b>	<b>7,184</b>	<b>-137</b>	<b>-2%</b>	<b>25%</b>
Бонд, өрийн бичиг	3,549	2,946.0	-603	-17%	
Зээл	3,772	4,238	466	12%	
<b>II. Төв банк</b>	<b>2,025</b>	<b>2,030</b>	<b>5</b>	<b>0%</b>	<b>7%</b>
<b>III. Банк</b>	<b>2,194</b>	<b>2,230.4</b>	<b>36</b>	<b>2%</b>	<b>8%</b>
Богино хугацаат	659	764.0	105	16%	3%
Урт хугацаат	1,535	1,466	-69	-4%	5%
<b>IV. Бусад сектор</b>	<b>7,956</b>	<b>8,042</b>	<b>86</b>	<b>1%</b>	<b>28%</b>
Богино хугацаат	666	609	-57	-9%	2%
Урт хугацаат	7,289	7,433	143	2%	26%
<b>V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл</b>	<b>7,996</b>	<b>9,228</b>	<b>1,232</b>	<b>15%</b>	<b>32%</b>

\*: Нийт өсөлтөд оруулсан хувь

Дүрслэл 9. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 10. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



#### Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

**ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)**

Үзүүлэлт	Он			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2016	2017	2018	Дүн	2017/16	Дүн	2018/17
<b>I. УРСГАЛ ДАНС</b>	<b>-700</b>	<b>-1,155</b>	<b>-2,207</b>	<b>-456</b>	<b>-65%</b>	<b>-1,051</b>	<b>-91%</b>
Бараа ба үйлчилгээний худалдаа	0	278	-1,303	278	55941%	-1,580	-569%
Кредит	5,605	6,801	7,668	1,196	21%	868	13%
Дебет	5,605	6,523	8,971	918	16%	2,448	38%
<b>1. Бараа</b>	<b>1,338</b>	<b>1,490</b>	<b>676</b>	<b>152</b>	<b>11%</b>	<b>-814</b>	<b>-55%</b>
1.1 Экспорт Ф.О.Б (кредит)	4,804	5,834	6,557	1,030	21%	722	12%
1.2 Импорт Ф.О.Б (дебит)	3,466	4,345	5,881	878	25%	1,536	35%
<b>2. Үйлчилгээ</b>	<b>-1,338</b>	<b>-1,212</b>	<b>-1,978</b>	<b>126</b>	<b>9%</b>	<b>-766</b>	<b>-63%</b>
Кредит	801	966	1,112	165	21%	145	15%
Дебет	2,139	2,178	3,090	39	2%	911	42%
2.1 Тээвэр	-176	-284	-561	-108	-61%	-277	-98%
Кредит	255	320	354	65	25%	34	11%
Дебит	431	604	915	172	40%	311	52%
2.2 Аялал	-166	-137	-415	29	17%	-278	-203%
Кредит	316	396	445	79	25%	50	13%
Дебит	482	533	860	50	10%	327	61%
2.3 Бусад үйлчилгээ	-996	-791	-1,003	205	21%	-211	-27%
Кредит	229	251	312	21	9%	62	25%
Дебит	1,225	1,042	1,315	-183	-15%	273	26%
<b>3 Анхдагч орлого</b>	<b>-911</b>	<b>0</b>	<b>-1,228</b>	<b>911</b>	<b>100%</b>	<b>-1,228</b>	
Кредит	68	76	346	8	12%	269	352%
Дебет	980	1,689	1,573	709	72%	-116	-7%
3.1 Ажилчдын цалин	-28	-44	185	-16	-57%	229	520%
3.2 Хөрөнгө оруулалтын орлого	-883	-1,574	-1,425	-691	-78%	149	9%
3.3 Бусад	0	6	13	6		8	
<b>4 Хоёрдогч орлого</b>	<b>212</b>	<b>180</b>	<b>324</b>	<b>-33</b>	<b>-15%</b>	<b>144</b>	<b>80%</b>
Кредит	305	264	448	-41	-13%	184	69%
Дебит	93	85	124	-8	-9%	40	47%
Үүнээс: Хувийн гуйвуулга	56	20	122	-36	-64%	102	505%
<b>II. ХӨРӨНГИЙН ДАНС</b>	<b>91</b>	<b>78</b>	<b>92</b>	<b>-13</b>	<b>-14%</b>	<b>14</b>	<b>18%</b>
<b>1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/ бууралт</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>		<b>0</b>	
Кредит	0	0	0	0		0	
Дебет	0	0	0	0		0	
<b>2. Хөрөнгийн шилжүүлэг</b>	<b>91</b>	<b>78</b>	<b>92</b>	<b>-13</b>	<b>-14%</b>	<b>14</b>	<b>18%</b>
Кредит	94	82	93	-12	-13%	12	14%
Дебет	3	4	2	1	39%	-3	-62%
<b>Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)</b>	<b>-609</b>	<b>-1,078</b>	<b>-2,115</b>	<b>-469</b>	<b>-77%</b>	<b>-1,037</b>	<b>-96%</b>
<b>III. САНХҮҮГИЙН ДАНС</b>	<b>-812</b>	<b>-2,593</b>	<b>-2,091</b>	<b>-1,781</b>	<b>-219%</b>	<b>502</b>	<b>19%</b>
<b>Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)</b>	<b>-812</b>	<b>-2,593</b>	<b>-2,091</b>	<b>-1,781</b>	<b>-219%</b>	<b>502</b>	<b>19%</b>
<b>1. Шууд хөрөнгө оруулалт</b>	<b>4,171</b>	<b>-1,446</b>	<b>-2,137</b>	<b>-5,617</b>	<b>-135%</b>	<b>-691</b>	<b>-48%</b>
1.1 Актив	14	49	37	34	236%	-12	-24%
1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	14	49	38	34	236%	-10	-21%
1.1.2 Өрийн хэрэгсэл	0	0	-1	0		-1	
1.2 Пассив	-4,156	1,494	2,174	5,651	136%	679	45%
1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	-399	828	1,000	1,227	308%	173	21%
1.2.2 Өрийн хэрэгсэл	-3,758	666	1,173	4,424	118%	507	76%
<b>2. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>-487</b>	<b>-493</b>	<b>-61</b>	<b>-6</b>	<b>-1%</b>	<b>432</b>	<b>88%</b>
2.1 Актив	13	-27	47	-40	-305%	73	276%
2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	1	-30	54	-31	-4938%	84	278%
2.1.2 Өрийн бичиг	12	4	-7	-9	-71%	-11	
2.2 Пассив	500	467	107	-33	-7%	-359	-77%
2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	4	-10	-7	-14	-379%	3	32%
2.2.2 Өрийн бичиг	496	477	114	-20	-4%	-362	-76%
<b>3. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд</b>	<b>38</b>	<b>17</b>	<b>-13</b>	<b>-21</b>	<b>-56%</b>	<b>-30</b>	<b>-176%</b>
3.1 Актив	-12	0	-12	12	97%	-12	-2876%
3.2 Пассив	-50	-17	0	33	66%	18	102%
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>-4,534</b>	<b>-671</b>	<b>119</b>	<b>3,863</b>	<b>85%</b>	<b>791</b>	<b>118%</b>
4.1 Актив	419	-349	-110	-767	-183%	239	68%
4.1.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах	327	-346	-22	-674	-206%	324	94%
4.1.3 Зээл	10	-4	-38	-13	-139%	-34	-901%
4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	82	1	-50	-80	-98%	-51	-3930%
4.1.5.1 Богино хугацаат	82	1	-50	-80	-98%	-51	-3930%
4.1.5.2 Урт хугацаат	0	0	0	0		0	
4.1.5 Бусад авлага	0	0	0	0		0	
4.2 Пассив	4,953	323	-229	-4,630	-93%	-552	-171%
4.2.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах	123	143	-33	19	16%	-176	-123%
4.2.3 Зээл	4,968	222	-142	-4,746	-96%	-365	-164%
4.2.3.1 Төв банк	0	0	0	0		0	
4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд	229	-264	-86	-492	-215%	178	67%
4.2.3.3.1 Богино хугацаат	53	-110	49	-162	-309%	159	145%
4.2.3.3.2 Урт хугацаат	176	-154	-135	-330	-187%	18	12%
4.2.3.2 Засгийн газар	571	848	487	277	49%	-360	-43%
4.2.3.4 Бусад салбар	4,169	-362	-543	-4,531	-109%	-182	-50%
4.2.3.4.1 Богино хугацаат	-77	-36	-142	41	54%	-107	-301%
4.2.3.4.2 Урт хугацаат	4,246	-326	-401	-4,572	-108%	-75	-23%
4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	-139	-42	-54	97	69%	-11	-27%
4.2.5.1 Богино хугацаат	-19	-42	-54	-23	-124%	-11	-27%
4.2.5.2 Урт хугацаат	-120	0	0	120		0	
4.2.6 Бусад авлага	0	0	0	0		0	
4.2.7 Зээлжих тусгай эрх	0	0	0	0		0	
<b>IV. Алдаа болон орхигдуулга</b>	<b>-221</b>	<b>-56</b>	<b>-118</b>	<b>166</b>	<b>1</b>	<b>-62</b>	<b>-1</b>
<b>V. НӨӨЦ ХӨРӨНГӨ</b>	<b>-18</b>	<b>1,460</b>	<b>-142</b>	<b>1,478</b>	<b>8126%</b>	<b>-1,602</b>	<b>-110%</b>
1. ГВУН	-18	1,577	-38	1,596	8772%	-1,616	-102%
2. ОУВС-гийн зээл	0	117	104	117		-14	
3. Тусгай санхүүжилт	0	0	0	0		0	

\* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.

## ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)

Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын үлдэгдэл, 2018 оны гүйцэтгэл

Үзүүлэлт	12/31/2011	12/31/2012	12/31/2013	12/31/2014	12/31/2015	12/31/2016	12/31/2017	03/31/2018	06/30/2018	09/30/2018	12/31/2018
<b>Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц</b>	<b>-12,314</b>	<b>-19,238</b>	<b>-24,642</b>	<b>-27,227</b>	<b>-28,629</b>	<b>-29,350</b>	<b>-32,031</b>	<b>-32,686</b>	<b>-32,768</b>	<b>-33,292</b>	<b>-33,637</b>
<b>Актив</b>	<b>6,127</b>	<b>6,753</b>	<b>4,340</b>	<b>4,045</b>	<b>3,907</b>	<b>4,309</b>	<b>5,553</b>	<b>5,627</b>	<b>5,647</b>	<b>5,397</b>	<b>6,149</b>
<b>Шууд хөрөнгө оруулалт</b>	<b>1,757</b>	<b>883</b>	<b>351</b>	<b>427</b>	<b>440</b>	<b>455</b>	<b>495</b>	<b>519</b>	<b>521</b>	<b>525</b>	<b>533</b>
<b>Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх</b>	<b>1,704</b>	<b>817</b>	<b>282</b>	<b>355</b>	<b>366</b>	<b>380</b>	<b>427</b>	<b>447</b>	<b>450</b>	<b>455</b>	<b>466</b>
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	1,704	817	282	355	366	380	427	447	450	455	466
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
үүнээс: Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Өрийн хэрэгсэл</b>	<b>54</b>	<b>66</b>	<b>69</b>	<b>72</b>	<b>73</b>	<b>75</b>	<b>68</b>	<b>72</b>	<b>71</b>	<b>70</b>	<b>67</b>
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	54	66	69	71	72	75	68	71	70	69	66
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	1	1	1	1	1	1	1	1
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>202</b>	<b>485</b>	<b>370</b>	<b>217</b>	<b>223</b>	<b>280</b>	<b>268</b>	<b>270</b>	<b>275</b>	<b>286</b>	<b>290</b>
<b>Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх</b>	<b>196</b>	<b>479</b>	<b>365</b>	<b>208</b>	<b>213</b>	<b>259</b>	<b>254</b>	<b>256</b>	<b>258</b>	<b>269</b>	<b>279</b>
Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	0	0	3	2	3	3	18	28	29	21	23
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	196	479	362	206	210	256	236	228	229	248	256
Бусад санхүүгийн байгууллага	32	77	92	129	163	165	168	172	184	193	210
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	165	402	270	76	47	91	69	56	45	56	46
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бүртгэлтэй	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бүртгэлгүй	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Өрийн бичиг</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>21</b>	<b>14</b>	<b>14</b>	<b>17</b>	<b>17</b>	<b>10</b>
Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	0	0	0	0	6	17	6	6	6	6	7
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	6	17	6	6	6	6	7
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	6	6	6	9	4	4	8	8	10	10	3
Богино хугацаат	6	6	6	6	0	0	1	1	3	3	3
Урт хугацаат	0	0	0	3	4	4	7	7	8	8	0
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	6	6	6	6	0	0	1	1	2	3	3
Урт хугацаат	0	0	0	3	4	4	7	7	1	8	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>49</b>	<b>121</b>	<b>114</b>	<b>100</b>	<b>-0</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>0</b>	<b>0</b>
Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	1	0	49	121	114	100	-0	6	6	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад санхүүгийн байгууллагууд	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Опцион	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Форвард хэлбэрийн хэлцлүүд	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Ажилчдын хувьцааны опцион	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>1,318</b>	<b>1,259</b>	<b>1,404</b>	<b>1,630</b>	<b>1,807</b>	<b>2,178</b>	<b>1,782</b>	<b>1,849</b>	<b>1,856</b>	<b>1,692</b>	<b>1,784</b>
<b>Бусад хөрөнгө</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Бэлэн мөнгө ба харилцах</b>	<b>1,033</b>	<b>896</b>	<b>1,100</b>	<b>1,225</b>	<b>1,443</b>	<b>1,746</b>	<b>1,328</b>	<b>1,477</b>	<b>1,441</b>	<b>1,292</b>	<b>1,283</b>
Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	500	530	489	311	441	762	461	605	643	532	461
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	533	366	611	913	1,002	984	867	872	798	759	822
<b>Зээл</b>	<b>14</b>	<b>15</b>	<b>6</b>	<b>49</b>	<b>50</b>	<b>62</b>	<b>61</b>	<b>60</b>	<b>60</b>	<b>60</b>	<b>150</b>
Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	9	15	2	47	49	61	60	60	60	60	150
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	5	0	3	2	1	2	-0	-0	-0	-0	-0
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	5	0	3	2	1	2	-0	0	0	-0	-0
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	271	348	298	357	314	370	392	313	355	340	352
Бусад дансны авлага/өглөг	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Нөөц хөрөнгө</b>	<b>2,847</b>	<b>4,126</b>	<b>2,166</b>	<b>1,650</b>	<b>1,323</b>	<b>1,296</b>	<b>3,008</b>	<b>2,983</b>	<b>2,989</b>	<b>2,894</b>	<b>3,542</b>

# Үргэлжлэл.

Үзүүлэлт	12/31/2011	12/31/2012	12/31/2013	12/31/2014	12/31/2015	12/31/2016	12/31/2017	03/31/2018	06/30/2018	09/30/2018	12/31/2018
<b>Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц</b>	<b>-12,314</b>	<b>-19,238</b>	<b>-24,642</b>	<b>-27,227</b>	<b>-28,629</b>	<b>-29,350</b>	<b>-32,031</b>	<b>-32,686</b>	<b>-32,768</b>	<b>-33,292</b>	<b>-33,637</b>
<b>Өр төлбөр</b>	<b>18,440</b>	<b>25,991</b>	<b>28,981</b>	<b>31,273</b>	<b>32,537</b>	<b>33,660</b>	<b>37,584</b>	<b>38,313</b>	<b>38,415</b>	<b>38,689</b>	<b>39,786</b>
<b>Шууд хөрөнгө оруулалт</b>	<b>13,333</b>	<b>17,668</b>	<b>19,579</b>	<b>20,247</b>	<b>20,696</b>	<b>16,277</b>	<b>18,020</b>	<b>18,566</b>	<b>19,121</b>	<b>19,579</b>	<b>20,223</b>
<b>Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх</b>	<b>7,380</b>	<b>8,641</b>	<b>8,989</b>	<b>9,206</b>	<b>9,575</b>	<b>8,851</b>	<b>10,023</b>	<b>10,330</b>	<b>10,660</b>	<b>10,708</b>	<b>10,995</b>
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	7,380	8,641	8,989	9,206	9,575	8,851	10,023	10,330	10,660	10,708	10,995
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
үүнээс: Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Өрийн хэрэгсэл</b>	<b>5,953</b>	<b>9,028</b>	<b>10,590</b>	<b>11,041</b>	<b>11,121</b>	<b>7,426</b>	<b>7,996</b>	<b>8,235</b>	<b>8,461</b>	<b>8,871</b>	<b>9,228</b>
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	5,953	9,028	10,590	11,041	11,121	7,426	7,996	8,235	8,461	8,871	9,228
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>564</b>	<b>2,895</b>	<b>2,494</b>	<b>2,877</b>	<b>3,067</b>	<b>3,631</b>	<b>4,937</b>	<b>4,758</b>	<b>4,394</b>	<b>4,505</b>	<b>4,887</b>
<b>Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх</b>	<b>151</b>	<b>140</b>	<b>114</b>	<b>94</b>	<b>80</b>	<b>71</b>	<b>71</b>	<b>71</b>	<b>69</b>	<b>79</b>	<b>75</b>
Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	11	11	11	11	11	11	11	11	11	21	21
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	140	129	103	83	69	60	60	60	58	58	54
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бүртгэлтэй	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бүртгэлгүй	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Өрийн бичиг</b>	<b>413</b>	<b>2,755</b>	<b>2,380</b>	<b>2,783</b>	<b>2,987</b>	<b>3,560</b>	<b>4,866</b>	<b>4,687</b>	<b>4,326</b>	<b>4,427</b>	<b>4,811</b>
Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	258	547	400	522	652	611	589	608	596	633	624
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	258	547	400	522	652	611	589	608	596	633	624
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	127	1,587	1,415	1,403	1,473	2,064	3,549	3,340	2,996	3,067	2,946
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	127	1,587	1,415	1,403	1,473	2,064	3,549	3,340	2,996	3,067	2,946
Бусад салбарууд	28	621	565	858	862	886	728	738	733	726	1,241
Богино хугацаат	0	0	0	0	2	2	2	2	2	2	2
Урт хугацаат	28	621	565	858	860	884	726	736	731	724	1,239
Бусад санхүүгийн байгууллага	20	613	559	837	828	850	266	284	272	274	787
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	20	613	559	837	828	850	266	284	272	274	787
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	8	9	7	21	32	34	460	452	459	451	451
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	8	9	7	21	32	34	460	452	459	451	451
<b>Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>49</b>	<b>124</b>	<b>166</b>	<b>116</b>	<b>-0</b>	<b>6</b>	<b>25</b>	<b>1</b>	<b>1</b>
Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	1	0	49	124	166	116	-0	6	25	1	1
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>4,542</b>	<b>5,427</b>	<b>6,859</b>	<b>8,025</b>	<b>8,608</b>	<b>13,635</b>	<b>14,628</b>	<b>14,983</b>	<b>14,875</b>	<b>14,604</b>	<b>14,675</b>
<b>Бусад хөрөнгө</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Бэлэн мөнгө ба харилцах</b>	<b>130</b>	<b>480</b>	<b>1,151</b>	<b>1,590</b>	<b>1,954</b>	<b>1,965</b>	<b>2,245</b>	<b>2,365</b>	<b>2,210</b>	<b>2,101</b>	<b>2,123</b>
Төв банк	0	337	990	1,449	1,772	1,725	1,837	1,913	1,811	1,744	1,745
Богино хугацаат	0	337	990	1,449	1,772	1,725	1,837	1,913	1,811	1,744	1,745
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	130	143	161	141	182	240	314	330	297	317	327
Богино хугацаат	130	143	161	141	182	240	314	330	297	317	327
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
үүнээс: Банк хоорондын позиц	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	95	122	102	40	51
<b>Зээл</b>	<b>4,063</b>	<b>4,559</b>	<b>5,275</b>	<b>5,963</b>	<b>6,396</b>	<b>11,454</b>	<b>12,102</b>	<b>12,345</b>	<b>12,392</b>	<b>12,261</b>	<b>12,265</b>
Төв банк	268	235	141	73	68	65	188	224	253	252	286
ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс бусад)	267	234	140	73	68	65	188	224	253	252	286
Бусад богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад урт хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	352	486	815	1,100	1,294	1,567	1,291	1,409	1,418	1,360	1,279
Богино хугацаат	111	106	260	357	407	469	345	439	480	460	437
Урт хугацаат	241	380	555	743	887	1,098	946	970	938	900	842
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	1,917	2,012	2,119	2,098	2,287	2,805	3,772	3,902	3,933	3,981	4,238
ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад урт хугацаат	1,917	2,012	2,119	2,098	2,287	2,805	3,772	3,902	3,933	3,981	4,238
Бусад салбарууд	1,526	1,826	2,200	2,692	2,747	7,017	6,850	6,811	6,787	6,668	6,462
Богино хугацаат	411	412	278	283	260	218	292	274	277	259	275
Урт хугацаат	1,115	1,414	1,922	2,409	2,487	6,800	6,558	6,536	6,510	6,409	6,187
Бусад санхүүгийн байгууллага	36	36	33	451	519	630	529	517	468	417	292
Богино хугацаат	1	1	1	1	1	1	41	42	43	43	44
Урт хугацаат	35	35	32	450	518	629	487	475	426	374	248
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	1,490	1,790	2,167	2,241	2,228	6,387	6,322	6,294	6,319	6,251	6,170
Богино хугацаат	411	412	278	282	259	217	251	232	234	216	231
Урт хугацаат	1,080	1,379	1,889	1,958	1,969	6,170	6,071	6,062	6,085	6,035	5,939
<b>Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Худалдааны зээл ба урьдчилгаа</b>	<b>350</b>	<b>389</b>	<b>433</b>	<b>424</b>	<b>138</b>	<b>216</b>	<b>280</b>	<b>274</b>	<b>273</b>	<b>242</b>	<b>288</b>
<b>Бусад дансны авлага/өглөг</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>48</b>	<b>120</b>	<b>0</b>	<b>0</b>				

**ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР ( мянган ам.доллар)**

Үзүүлэлт	12/30/2016	12/31/2017	3/31/2018	6/30/2018	9/30/2018	12/31/2018
<b>Засгийн газар</b>	<b>4,868,606</b>	<b>7,320,975</b>	<b>7,242,453</b>	<b>6,929,304</b>	<b>7,048,571</b>	<b>7,184,193</b>
<b>Богино хугацаат</b>	-	-	-	-	-	-
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
<b>Урт хугацаат</b>	<b>4,868,606</b>	<b>7,320,975</b>	<b>7,242,453</b>	<b>6,929,304</b>	<b>7,048,571</b>	<b>7,184,193</b>
Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/	-	-	-	-	-	-
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	2,063,528	3,548,542	3,340,397	2,995,995	3,067,325	2,946,032
Зээл	2,805,078	3,772,434	3,902,056	3,933,308	3,981,246	4,238,161
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
<b>Төвбанк</b>	<b>1,790,751</b>	<b>2,025,079</b>	<b>2,136,576</b>	<b>2,064,703</b>	<b>1,995,912</b>	<b>2,030,222</b>
<b>Богино хугацаат</b>	<b>1,725,434</b>	<b>1,837,133</b>	<b>1,912,712</b>	<b>1,811,484</b>	<b>1,743,626</b>	<b>1,744,562</b>
Харилцах, хадгаламж 5/	1,725,434	1,837,133	1,912,712	1,811,484	1,743,626	1,744,562
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
<b>Урт хугацаат</b>	<b>65,317</b>	<b>187,946</b>	<b>223,864</b>	<b>253,218</b>	<b>252,286</b>	<b>285,660</b>
Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/	65,317	187,946	223,864	253,218	252,286	285,660
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
<b>Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)</b>	<b>2,417,380</b>	<b>2,194,264</b>	<b>2,346,852</b>	<b>2,310,780</b>	<b>2,309,291</b>	<b>2,230,371</b>
<b>Богино хугацаат</b>	<b>469,093</b>	<b>659,008</b>	<b>769,008</b>	<b>776,745</b>	<b>776,901</b>	<b>764,047</b>
Харилцах, хадгаламж 5/	-	313,669	330,056	296,720	316,964	326,765
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-
Зээл	469,093	345,339	438,952	480,025	459,937	437,283
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
<b>Урт хугацаат</b>	<b>1,948,288</b>	<b>1,535,256</b>	<b>1,577,844</b>	<b>1,534,035</b>	<b>1,532,389</b>	<b>1,466,323</b>
Харилцах, хадгаламж 5/	239,612	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	611,048	589,222	608,231	596,325	632,753	624,396
Зээл	1,097,628	946,034	969,613	937,710	899,636	841,927
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
<b>Бусад салбарууд</b>	<b>8,121,485</b>	<b>7,955,844</b>	<b>7,944,407</b>	<b>7,895,491</b>	<b>7,676,427</b>	<b>8,041,874</b>
<b>Богино хугацаат</b>	<b>394,395</b>	<b>666,472</b>	<b>664,933</b>	<b>647,164</b>	<b>535,544</b>	<b>609,018</b>
Харилцах, хадгаламж 5/	-	94,606	121,945	101,945	40,009	51,278
Өрийн бичиг 4/	2,120	2,120	2,120	2,120	2,120	2,120
Зээл	217,529	292,414	274,451	277,191	258,888	274,704
Худалдааны зээл болон урьдчилгаа	174,746	277,332	266,418	265,909	234,527	280,915
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
<b>Урт хугацаат</b>	<b>7,727,090</b>	<b>7,289,372</b>	<b>7,279,474</b>	<b>7,248,327</b>	<b>7,140,883</b>	<b>7,432,856</b>
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	883,672	726,032	736,129	731,154	724,309	1,238,669
Зээл	6,801,973	6,560,413	6,536,227	6,510,054	6,409,456	6,187,069
Худалдааны зээл болон урьдчилгаа	41,445	2,927	7,118	7,118	7,118	7,118
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
<b>Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг</b>	<b>7,426,277</b>	<b>7,996,494</b>	<b>8,235,177</b>	<b>8,460,697</b>	<b>8,871,427</b>	<b>9,228,228</b>
Шууд хөрөнгө оруулагчид өгөх өглөг	7,426,277	7,996,494	8,235,177	8,460,697	8,871,427	9,228,228
Шууд хөрөнгө оруулагчийн өгөх өглөг	-	-	-	-	-	-
Хамааралтай компани хоорондын өглөг	-	-	-	-	-	-
<b>Нийт гадаад өр</b>	<b>24,624,500</b>	<b>27,492,657</b>	<b>27,905,465</b>	<b>27,660,975</b>	<b>27,901,628</b>	<b>28,714,887</b>